



АЛТАЙ ОВГИЙН ХЭЛНҮҮДИЙН ҮГИЙН САНГ УТГА ЗҮЙН
АРГААР СУДЛАХ НЬ

В.И.Рассадин⁵⁷

Орос хэлнээс орчуулсан: Б.Даваасүрэн⁵⁸

Алтай овгийн үндсэн хэл болох түрэг, монгол, манж-түнгүс хэлнүүд төрлийн холбоотой гэх асуудлыг XIX зууны дунд үеэс эхэлж хөндсөн хэдий ч одоог хүртэл бүрэн шийдэж чадаагүй байна. Алтай судлалын өнөөдрийн дүр зургийг харвал энэ асуудлыг амжилттай шийдэж чадна гэсэн найдлага хараахан алга. Ирээдүйд хийх ажил бололтой.

Алтай судлалд хэрэглэж буй судалгааны арга барилын нэг сул тал бол үнэндээ түүхэн-харьцуулсан хэл зүйн эрэл хайгуул, шинжилгээ судалгааны ажилдаа урьдчилсан таамгаар хоорондоо төрөл хэмээн тооцогдож буй хэлнүүдийн үгийн санг задлан шинжлэхдээ үгийн сан судлалын судалгааны аргыг дутуу үнэлсэнд оршиж байгаа юм. Алтай овогт багтдаг хэлнүүдийн үгийн сангийн материал хэрэглэгдэхүүнийг алтай судлаачид ихэнхдээ гаднах хэлбэр таардаг үгсийн хүрээнд авианы тохироог тогтоохын тулд ашиглаж ирсэн хэмээн В.И.Цинциус зөв зүйтэй тэмдэглэж байжээ⁵⁹. Бидний үзэж байгаагаар энэ аргыг одоо ч хүчин төгөлдөр хэрэглээд зогсохгүй харин ч чухалд тооцогдож, энэ талаар: “...алтай хэл шинжлэлд гарсан үр дүнг шалгах ба батлах төдийгүй түүнчлэн алтай овгийн хэлнүүд хоорондоо төрөл холбоотой болох талаар нэмэлт баримт нотолгоо илрүүлж гаргахад бодтой баримт хэрэглэгдэхүүний цар хүрээг тэлэх, тэдгээрийг дүгнэн шинжлэх арга барилыг гүнзгийрүүлэх шаардлагатай байна. Гаднах хэлбэрийн хувьд тохирч буй шинэ үгийг (түүнчлэн авиа болон үг зүйн тохироог) сонгож авах үр дүнтэй аргуудын нэг бол алтай овгийн хэлнүүдийн үгийн санг өргөн хүрээнд зүйлчилсэн байдлаар тоймлон тогтоох явдал юм” хэмээжээ.⁶⁰ Энэхүү санааг засахын ялдамд алтай овгийн хэлнүүдийн үгийн санг тодорхой хүрээнд зүйлчлэн судлах ба утга зүйн үүрийг судлах нь алтай овгийн хэлнүүдэд нийтлэг байдаг алтай хэл шинжээч эрдэмтдийн тодорхой хүрээ бүрд урьдчилан тогтоож чаддаг төрөл шинжүүдийг илрүүлэхэд тустай төдийгүй бодитоор салсан үе, ормол үгийн харилцан адилгүй нөхцөл буюу өөрөөр хэлбэл, эдгээр хэлний хоорондын адил төстэй хийгээд зөрүүтэй талуудыг бодитоор, зүй тогтлынх нь хүрээнд

⁵⁷ Валентин Рассадин Иванович (1939-2017). Оросын Холбооны Улсын хэлшинжээч эрдэмтэн. Хэл бичгийн ухааны доктор, профессор, ОХУ-ын ШУА-ийн байгалийн шинжлэх ухааны сурвалжлагч гишүүн. Судалгааны чиглэл нь монгол-түрэг хэлний түүхэн харьцуулсан хэлшинжлэл бөгөөд 1978 онд тофалар хэлний цагаан толгойг зохиосон нэрт монгол, түрэг судлаач эрдэмтэн.

⁵⁸ МУИС, Монгол хэл, хэлшинжлэлийн тэнхим, дэд профессор

⁵⁹ В.И.Цинциус. *Вопросы сравнительной лексикологии алтайских языков // Проблемы общности алтайских языков. Л.: Наука, 1971. стр., 78.*

⁶⁰ Мөн тэнд

судлах боломжтой болно гэдгийг тэмдэглэх нь зүйтэй юм. Бид С.Е.Яхонтовын хэлсэн: «... адил төстэй шинж тооны хувьд олон байлаа гээд төрөл гэдгийн баталгаа огт болохгүй; хэрэв төрөл хэлнүүдийн салсан он цаг хэт холдсон бол нийтлэг үг маш цөөхөн хадгалагдаж үлдсэн байдаг. Тиймээс тохирч байгаа үгийн тоо чухал бус харин тэдгээр үгийг утгын хувьд хэрхэн бүлэглэж байгаа нь чухал юм. Түүнчлэн ганцхан үгийн хувьсал түүхийг утгын хүрээнээс нь салгаж авч үзэх явдал бас чухал биш»⁶¹ гэсэн саналтай бүрэн нийлж байгаа болно. Алтай судлалын хүрээнд үгийн сангийн судлалтай холбогдуулж С.Е.Яхонтовын «...төрөл хэлнүүдэд (ө.х. гарал нэгтэй хэлнүүдэд) үгийн сангийн тогтвортой хэрэглэгддэг бүлэг үгсийн хүрээнд тооны хувьд ч үгийн сангийн хувьд ч тохирдог үгс их тохиолддог. Үүнээ дэд утгатай үгнээс илүүтэй бүлэг бүрийн дотор багтдаг харьцангуй тогтвортой хэрэглэгддэг үгс хоорондоо тохирох нь их. Хэл нийлэх (конвергенция) явцын үр дүнд ойртож хэлний нийтлэг хэв шинжтэй болсон (эсвэл өнгөрсөнд нийтлэг хэв шинжтэй байсан) хэлнүүдэд тохирдог дундын үгийн дийлэнх нь соёлын хүрээнд хамаарах үг байдаг бол бусад салбарт тэр бүр чухал ойлголт ухагдахуун тэмдэглэдэггүй. Бусад хэлнээс орох боломж багатай, нэг утга зүйн хүрээнд багтдаг үгс тохирох нь цөөн байдаг нь нийтлэг хэв шинжтэй болсон хэлнүүдэд тэр мэт үгс угаасаа хэлэнд байдаг буюу уугуул үгс байдаг» хэмээсэн дүгнэлт маш чухал.⁶²

Хэдийгээр алтай овгийн хэлнүүдийг хоорондоо гарлын холбоотой хэмээн тооцдог эрдэмтдийн саналаас гадна орчин цагийн алтай овгийн хэлнүүдийн хооронд тэр дундаа түрэг ба монгол хэлний хооронд илэрдэг гайхмаар ижил төстэй шинжүүд нь гарал зүйн хувьд холбоотой байсны үр дүн бус харин түүхэн урт удаан хугацааны конвергенцийн үйл явц хийгээд харилцан нөлөөллийн үр дүн. Эдгээр хэлний үгийн сангийн түвшинд тохирч байгаа болон тохирдоггүй хэсгийг чухамхүү үгийн сангийн бүрэлдэхүүн хэсгүүдийг тодорхой бүлэг үгсийн хүрээнд судалж тогтоох боломжтой бөгөөд бидний үзэж байгаагаар зөвхөн дундын үгсийг харьцуулаад зогсохгүй басхүү нэг утга зүйн хүрээнд багтааж буй бүх нэр томьёоны зүйлийг ч тохирдог ба тохирдоггүй гэж ялгалгүй судалгаанд хамруулах хэрэгтэй юм. Үүнээ нэг тодорхой бүлэг хэлний тухайд дундын шинжтэй эсвэл хоёр хэлний дундын шинжтэй нэр томьёоны зүйлийг зэрэгцүүлэн судлах нь дүгнэлт хийх үндэслэл болох буюу өөрөөр хэлбэл, нийт түрэг хэлний эсвэл түрэг хэл хоорондын, нийт монгол хэлний гэх мэтээр илрүүлж тогтоосон нэр томьёог зэрэгцүүлэн судалбал зохилтой.

Алтай овгийн хэлнүүдийн үгийн санг судлахад утга зүйн арга маш чухал болохыг харгалзан үзээд, бид энэхүү аргыг зарим нэгэн утгын бүлэг үгийн хүрээнд монгол хэл болон тодорхой түрэг хэлний үгийн санг судлах ажилдаа ашиглах оролдлого хийсэн болно.⁶³

Тус аргаар ямар ч хэлний үгийн санг гэхдээ алтай судлалын хүрээнд судалснаар санаанд оромгүй үр дүнд хүрсэн билээ. Зарим нэгээс нь тодорхойлон дурдваас.

Загас, ан агнуурт холбогдох монгол хэлний үгийн сангийн түүхэн харьцуулсан судалгаандаа бид зөвхөн ан агнуур, загас агнуурын зэвсэг, хэрэгсэл, аргуудын нэрийг багтаагаад зогсоогүй мөн түүнчлэн зэрлэг ан амьтдын нэр, загас агнуурын нэр нэршлийг авч үзвээс энэхүү утга зүйн хүрээнд

⁶¹ Яхонтов С.Е. *Лексика как признак родства языка // Проблемы общности алтайских языков. С. 112*

⁶² Мөн тэнд

⁶³ Рассадин В.И. *К сравнительному изучению анималистской лексики бурятского языка // Языки фольклор народов Севера.* Новосибирск: Наука, 1981. Стр. 97-119; Мөн *Бурятская животноводческая терминология как источник по исторической этнографии // Этническая история и культурно-бытовые традиции в Бурятии.* Улан-Удэ, 1984. Стр. 55-80; Мөн *Охотничье-рыболовческая лексика в шорском языке // Диалектная лексика тюркских языков Сибири.* Новосибирск, 1987. Стр. 64-75.

багтдаг бүх үндсэн нэр томьёо бол нийт монгол хэлнийх бөгөөд өвөг монгол хэлнээс үүсэлтэй байгаа нь хожим салбарлан хөгжиж амжаагүй нэгэн нэгдмэл хэл байсан цаг үеийн эртний өвөг монголчууд тайгын ан араатан, жигүүртэн шувуу агнадаг, загас барихдаа тор болон сэрээ, дэгээ ашигладаг байсны баталгаа болж байна. Сонирхолтой нь ой тайгын туурайтан амьтад ба үслэг ан араатныг нэрлэсэн нийт монгол хэлний нэршил түрэг хэлнийхтэй тохирдоггүй зөвхөн манж- түнгүс хэлнийхтэй тохирдог. Жишээлбэл: монг: *хандагай* “лось” – түр: *булан* “лось”; монг: *гөрүгэсүн* “олень”, “косуля” – түр: *кийик*, *күлмүз* /гөрөөсний эр/, *элик* /гөрөөсний эм/; монг: *гахай*, *бодон гцахай* “свинья, кабан” – түр: *кабан*, *чочка*, *доңгуз*; монг: *хүдэргэ* “кабарга” – түр: *табырга*; монг: *чоно* “волк” – түр: *бөрү*; монг: *баабгай* “медведь” – түр: *адыг*, *азыг*, *айу*; монг: *үнэгэн* “лиса” – түр: *тирки*; монг: *хэрмэн* “белка” – түр: *тийиң* гэх мэт. Гэхдээ *хулан*, *зээр*, *арслан*, *цөөвөр чоно* гэх мэт зөвхөн тал хээрийн ан араатны нэр нь түрэг хэлний үгтэй дүйдэг. Түүнчлэн *тэх*, *аргаль*, *барс* гэх мэт уул нуруудаар амьдардаг ан амьтны нэр бас түрэг хэлний үгтэй дүйж байна. Алтай овгийн хэлэнд нийтлэг тохирдог үг бол зөвхөн *буга*, *марал* гэдэг үгтэй холбоотой үгс юм. Жишээлбэл, монг: *буга* – түр: *бугу*, тунг.-манж : *бугу*, *бухэ* “эр буга”; монг: *согоон* – түр: *сыгун*, тунг.-манж : *согон*, *сахэ* “эм буга” харьцуулна уу. Алтай овгийн бусад хэлэнд тохирдог ихэнх нэр томьёо нэг бол түрэг-монгол эсвэл монгол-манж-түнгүс хэлнүүдийн хооронд тохирдог (үүнд *хандгай*, *бор гөрөөс*, *бодон*, *цаа буга*, *нохой зээх*, *солонго*, *дорго*, *сарьсан багваахай*, *хулгана*, *жирх* буюу өөрөөр хэлбэл ой тайгын бүсийн амьтад). Зэрлэг араатныг заасан нийтлэг нэр түрэг- монгол хэлэнд *аң* гэсэн хэлбэрээр байгаа нь сонирхолтой юм (тунг.-манж: *бэйнгэ*, *бэюн* харьцуулна уу).

Эртнээс нааш нэрлэж ирсэн балар эртний үед бүрэлдэж тогтсон зэр зэвсэг болон ан агнуурын хэрэгслийн уламжлалт нэр томьёог болох *жад*, *хутга*, *сүх*, *нум*, *сум* авч үзвэл:

<u>түрэг</u>	<u>монгол</u>	<u>тунг.-манж.</u>	<u>утга</u>
сүнгү	джида	геда, гида	жад
бычак	*кытуга	кото	хутга
балта	сүкэ	сукэ	сүх
йа	нумун	бэр	нум
оқ	сумун	нюр	сум

Баримтаас харвал зөвхөн *нум*, *сум* хэмээх нэр алтай овгийн хэл бүрд өвөрмөц байдаг бол эртний зэр зэвсгийн нэр болох *жад*, *хутга*, *сүх* зөвхөн монгол ба манж-түнгүс хэлэнд нийтлэг байна. Түрэг хэлнүүдэд эдгээр нэр томьёо өвөрмөц байдаг.

Загас агнуурын үндсэн нэр томьёог харьцуулж үзвээс энэхүү утгын хүрээнд багтах үгс алтай овгийн хэлнүүдэд бүгд өвөрмөц өөр хэлбэртэй байдаг. Зарим нэгэн жишээг харьцуулж үзнэ үү:

<u>түрэг</u>	<u>монгол</u>	<u>манж-тунг.</u>	<u>утга</u>
балық	джигасун	/х/олло	загас
қармақ	гахуули	хинна	уурга
илмек	гөхү	каман	дэгээ

тор	гувчуур	адыл	тор
чанчкы	сэрэгэ	бадār, аркивүн	сэрээ
сүген	гүр	кэнгэр	томорцог
туғ	шибэгэ	укй	далдавч

Энэ мэтчилэн нэг утгын хүрээнд багтдаг үгсийг гүймэг харах төдийд мал аж ахуй эрхэлж эхлэхээс өмнөх эртний ан ав болон загас агнуурын дүр зураг харагдах бөгөөд алтай овогт багтдаг хэл тус бүрийн үндсэн нэр томьёо өөрийн гэсэн өвөрмөц шинжтэй байдгийг илтгэнэ. Ялангуяа монгол-манж-түнгүс хэлний нийтлэг шинж бол бодитой хийгээд илэрхий ажээ. Харин түрэг-монгол хэлэнд харьцангуй сул илэрч байна.

Бидний хийсэн өөр нэгэн өргөн утгын хүрээг хамардаг мал аж ахуйтай холбоотой хийгээд зөвхөн гэрийн тэжээвэр амьтдын нэр төдийгүй гэрийн тэжээвэр амьтдыг адгуулах ба аж ахуйдаа ашиглах хэрэглэхтэй холбоотой нэр томьёоны түүхэн харьцуулсан шинжилгээ судалгаагаар тогтоосон зүйл гэвэл түрэг-монгол хэлэнд үхэр, тэмээ, хонь, ямааны нэр мөн түүнчлэн сүүн бүтээгдэхүүний нэр нийтлэг байна. Адуутай холбоотой нэр томьёонууд түрэг хэлэнд өвөрмөц хэлбэртэй /түр. *ат* “морь”, *бе* “гүү”, *кулун* “унага”, *тай* “даага” харьцуулна уу/ байхад харин монгол хэлний /*морин*, *хэгү*, *унаган*, *даган*/ зохих нэрс түнгүс-манж хэлний /*морин*//*мурин*; *гэо*//*гдг*, *гдг*; *унахан*//*унукāн*/-тай тохирч байна. Түрэг хэлнүүдэд малын хашаа хороо болон өвс бэлдэхтэй холбоотой нийтлэг нэр томьёо бүрэлдсэнгүй аж. Харин монгол хэлэнд *хүрээ*, *хашаа*, *хот*, *дал*; *хажуур*, *хадах*, *хадлан*, *бухал*, *цомоо* гэх мэт нийт монгол хэлний нэр томьёо бүрэлдэн тогтсон байдаг нь тунгүс-манж хэлний зохих нэр томьёотой дүйцдэг. Энэ нь монголчуудын өвөг дээдэс суурин хэлбэрийн мал аж ахуйтай ба өвс тэжээл бэлддэг суурьшмал эсвэл хагас суурьшмал амьдралын хэв маягтай байсны баталгаа бөгөөд түрэг угсаатнууд малаа задгай тал газар бэлчээдгээрээ ялгаатай байжээ.

Бидний бодлоор нэг утгын хүрээнд багтдаг үгсийн судалгаа хийх энэ аргыг өргөн хүрээнд тууштай хэрэглэх хэрэгтэй байгаагийн учир гэвэл алтай овогт багтдаг хэлний үгийн санг шинжлэн дүгнэхэд алтай овгийн хэлнүүдийн нийтлэгийг шинээр харах, алтай овгийн хэлнүүдийн нийлсэн ба салсан түүхэн хөгжлийг бодитоор дүгнэх боломж олгох юм.

Институт востоковедения РАН
Всероссийская Ассоциация Монголоведов

**VI Международный конгресс
МОНГоловедов**
(Улан-Батор, август 1992 г.)

Доклады российской делегации

II

**Филология. Культура.
Религия.**

Москва
1992